

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ,  
МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ЗАХИРАМЖ

2024 оны 12 дугаар  
сарын 04 ны өдөр

Дугаар А/74 А/85

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Улс төрийн намын бүртгэлийн баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийн мэдээллийг хүргүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын Улс төрийн намын бүртгэлийн албаны дарга, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын дарга нарт даалгасугай.

3. Журмыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.





## УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ, ТҮҮНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Улс төрийн намын тухай хуульд заасан журмын дагуу Улсын дээд шүүхээс улс төрийн намын бүртгэл хийсэн шийдвэрийн талаарх мэдээлэл, шийдвэрт холбогдох баримтыг улс төрийн нам /цаашид нам гэх/-ын бүртгэсэн баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх мэдээлэлд Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасан дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

1.2.1. Улсын дээд шүүхэд шинээр үүсгэн байгуулагдсан нам бүртгүүлэх өргөдөл гаргагчийн мэдээлэл, дүрэм, намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаягийн мэдээлэл, намын хөрөнгийн мэдээлэл, зардлыг тусгасан тайлан;

1.2.2. намын албан ёсны хаяг болон өөрчлөгдсөн хөрөнгийн мэдээлэл;

1.2.3. намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын дарга өөрчлөгдсөн талаарх мэдээлэл, Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны шийдвэр;

1.2.4. намыг идэвхтэйд, эсхүл идэвхгүйд тооцох тухай Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны шийдвэр.

### Хоёр. Мэдээлэл хүргүүлэх үйл ажиллагаа

2.1. Улсын дээд шүүх энэ журмын 1.2.1-1.2.4-т заасан баримт, мэдээллийг бүртгэсэн шүүхийн шийдвэрийг албажсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан мэдээлэл, баримт, шийдвэрийг цахим хэлбэрээр хүргүүлж болно.